

2017 оны 10 сарын 27

Хавсралт 1  
Улаанбаатар хот

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬАТЫН ГАЗРЫН 10 ДУГААР САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МЭДЭЭ  
/2017.09.26 -2017.10.25/

**Нэг. “Иргэдэд ойр, эрх зүйн үйлчилгээний ажлын төлөвлөгөө”-ний хэрэгжилт**

Д/д	Авч хэрэгжүүлэх ажил, үйлчилгээ	Хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилт
1	2	3	4	5
Нэг. Төлөвлөлт, зохион байгуулалт, үйлчилгээ				
1	1.44. Ажлын гүйцэтгэлд тухайн байгууллага улирал тутам, яам оны эцэст тайланг авч хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийж үнэлэлт, дүгнэлт өгөх	XII сард	Ажлын тайланг нэгтгэн сайдад танилцуулан гүйцэтгэл үр дүнгээр нь байгууллага, хамт олон, албан хаагчдыг шагнаж урамшуулах, хариуцлага тооцох асуудлыг шийдвэрлэнэ.	Төсвийн төвлөрүүлэн захирагчийн үр дүнгийн гэрээний 3 дугаар улирлын биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн 10 дугаар сарын 05-ны өдрийн 1/01-3113 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргад хүргүүлсэн. Мөн байгууллагын 2017 оны 09 дүгээр сарын үндсэн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж тайланг удирдлагад 10 дугаар сарын 09-ний өдөр танилцуулж чиглэл авч ажилласан.
Хоёр. Иргэд, олон нийтэд чиглэсэн сурталчилгаа				
2	2.2. Олон нийтийн 2-4 телевизтэй тогтмол хамтран ажиллах гэрээ байгуулж, үйл ажиллагаагаа батлагдсан хуваарийн дагуу тогтмол сурталчилж ярилцлага, хэлэлцүүлэг зохион байгуулах	Тухай бүр	Байгууллагын үнэлэмж, иргэдийн эрх зүйн боловсрол дээшилнэ.	Байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээ, эрх зүйн зохицуулалт, онцлогийн талаар хэвлэл мэдээллийн байгууллагын сэтгүүлчдэд таниулах, сурталчлах ажлын хүрээнд MYOHT, ТВ5, UBS, MN25 телевиз, gogo.mn, ikon.mn, todaynews.mn сайт, Үндэсний шуудан сонины сэтгүүлчдийн багийг 2017 оны 10 дугаар сарын 20-ноос 25-ны өдрүүдэд Дорноговь аймаг дахь газрын үйл ажиллагаатай танилцуулж мэдээлэл сурвалжлага бэлтгэлээ.
3	2.3. Бүх агентлаг, байгууллага мэдээллийн цахим орчинд /твиттер, фэйсбүүк/ албан ёсны хаягтай болж, үйл ажиллагаагаа олон нийтэд тогтмол мэдээлж, сурталчилж хэвших	Тухай бүр	Мэдээллийн ил тод, нээлттэй байдал сайжирч, хүртээмж дээшилнэ.	Байгууллагын үйл ажиллагааг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчлах ажлын хүрээнд үйл явдлын мэдээ мэдээллийг бэлтгэн олон нийтэд түгээн ажиллалаа. Тухайлбал, Хэвлэлийн тоног төхөөрөмжийн тусламж үзүүлэх төсөл хэрэгжинэ, ЕАБХАБ-ын тусгай төлөөлөгч, элчин сайд, хатагтай Мадина Ярбуссиноваг хүлээн авч уулзлаа,

1	2	3	4	5
				<p>Байгууллагын спортын наадам боллоо, Зарим албан хаагчид нийтийн аж ахуйн салбарын тэргүүний ажилтан тэмдгээр шагнагдлаа, Д.Мөрөн Төрийн албаны тэргүүний ажилтан боллоо, Мэдээллийн цаг арга хэмжээ зохион байгуулагдлаа зэрэг үйл явдлын мэдээ, мэдээллийг олон нийтийн цахим сүлжээ болон арилжааны цахим сайтуудаар олон нийтэд түгээсэн. Дээрх үйл явдалтай холбогдуулан зураг, видео бичлэгийг архивлаж, байгууллагын цахим хуудсанд тухай бүр баяжилт хийн, мэдээ мэдээллийг шинэчлэн ажилласан.</p> <p>Мөн Өмнөд бүс дэх газрын мэргэжилтэн С.Мөнхтүвшингийн ярилцлагыг бэлтгэж 8 цахим хуудсаар түгээсэн.</p>
4	<p>2.4. Агентлаг, байгууллагууд олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, цахим орчиноор мэргэжлийн ур чадвар, эр зориг, ур чадвар гаргаж сайн үйл бүтээсэн, ажилласан албан хаагчдыг алдаршуулах, гавьяаг нь мөнхжүүлэх, үлгэр дууриал болгох ажлыг тогтмол зохион байгуулж хэвших</p>	Тухай бүр	<p>Иргэд, олон нийтэд салбарын байгууллага, албаны үйл ажиллагааны онцлог, мэргэжлийн бахархлыг сурталчлах, харилцан итгэлцлийг бэхжүүлж, албан хаагчдын ажлын үр дүн, сахилга, хариуцлага, ур чадвар сайжирна.</p>	<p>Энэ сард тус байгууллагад мэргэжлийн ур чадвар, эр зориг гаргаж, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр алдаршуулсан албан хаагч байхгүй байна.</p>
5	<p>2.5. Шинээр батлагдан гарсан хууль, тогтоомж, дүрэм, журам, бусад эрх зүйн актыг иргэд, олон нийтэд сурталчлан таниулах</p>	Сар бүр	<p>Иргэдийн эрх зүйн боловсрол дээшилсэн байна.</p>	<p>2017 оны 10 дугаар сард хууль сурталчлах ажлын хүрээнд Виз зөвшөөрлийн мэргэжилтэн Х.Энэрэлбаяр /50 сек/-ын хөтлөн явуулсан Бүртгэл хяналтын журамтай холбоотой видео шторк, мөн Виз зөвшөөрлийн газрын мэргэжилтэн Д.Болорцэцэг /1.42 сек/-ийн хөтлөн явуулсан Оршин суух зөвшөөрлийн талаарх шторкийг Англи монгол хэл дээр бэлтгэн байгууллагын цахим хуудас болон хандалт өндөртэй 5 сайтад байршуулан олон нийтэд түгээлээ.</p>
6	<p>2.7. Байгууллагын үйл ажиллагаа, үзүүлэх үйлчилгээний талаар богино хэмжээний шторк /30 сек-1 мин/ тогтмол хийж, хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон цахим сүлжээгээр тогтмол хүргэх, сурталчилах</p>	Улирал бүр	<p>Мэдээллийн цар хүрээ, хүртээмж сайжирч, харилцан түншлэл хангагдана.</p>	<p>Гадаадын иргэн, харьяатын газрын дарга Д.Мөрөнгийн ярилцлагыг “Өнөөдөр” сонины 2017 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн дугаарт нийтлүүлсэн ба тус байгууллагын дарга Д.Мөрөн АНУ дахь Монгол телевизийн “Студийн цаг” нэвтрүүлэгт байгууллагын үйл ажиллагаа, эрхлэх чиг үүргийн талаар дэлгэрэнгүй ярилцлага өглөө.</p>
7	<p>2.20 Жилийн хугацаанд хийсэн ажлынхаа талаар 30 минутаас 1 цагийн нэвтрүүлэг бэлтгэж телевиз, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр олон нийтэд тайлагнах</p>	Улирал, бүтэн жилээр	<p>Иргэдийн эрх тэгш байдлыг бүх шатанд хангах ажил, агентлаг, байгууллагад өгөх олон нийтийн үнэлэмж дээшилсэн, мэдээллийн ил тод, нээлттэй байдал хангагдсан байна.</p>	<p>Гадаадын иргэн, харьяатын газрын дарга Д.Мөрөнгийн ярилцлагыг “Өнөөдөр” сонины 2017 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн дугаарт нийтлүүлсэн ба тус байгууллагын дарга Д.Мөрөн АНУ дахь Монгол телевизийн “Студийн цаг” нэвтрүүлэгт байгууллагын үйл ажиллагаа, эрхлэх чиг үүргийн талаар дэлгэрэнгүй ярилцлага өглөө.</p>

### **Хоёр. Эрх зүйн мэдээлэл сургалт, сурталчилгааны хүрээнд хийсэн ажил**

1. 2017 оны 10 дугаар сарын 06-ны өдөр шинэчлэн батлагдсан байгууллагын “Хөдөлмөрийн дотоод журам”-ын танилцуулга сэдвээр хуулийн ахлах мэргэжилтэн М.Уранбилэг, 2017 оны 10 дугаар сарын 25-ны өдөр “Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэргээс сэргийлэх нь” сэдвээр Хан-Уул дүүргийн Замын цагдаагийн хэлтсийн зохицуулагч, цагдаагийн ахлах дэслэгч Ц.Эрдэнэбат нар тус тус төвийн албан хаагчдад сургалт зохион байгуулав.
2. “Мэргэшүүлэх сургалт зохион байгуулах тухай” байгууллагын дэд даргын 2017 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн А/413 дугаар тушаалаар сургалтын хоёрдугаар ээлжийн сургалтыг 2017 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр, гуравдугаар ээлжийн сургалтыг 10 дугаар сарын 09-ний өдрөөс тус тус эхлүүлэн боомт орон нутаг дахь газрын болон шинээр томилогдсон 31 албан хаагчийг хамруулж, хөтөлбөрийн дагуу зохих цагийн хичээлийг тэнхимд, үлдсэн цагийн хичээлийг Виз зөвшөөрлийн газар болон Буянт-Ухаа дахь газруудад практик арга зүйгээр зохион байгуулж, шалгалт аван, шалгалтын үр дүнгээр давтан сургалт, бусад арга хэмжээнүүдийг авч ажиллалаа.
3. Мөн 2017 оны 10 дугаар сарын 23-ны өдөр “Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг гаргахад анхаарах асуудал” сэдвээр тус байгууллагын Буянт-Ухаа дахь газрын албан хаагчдад хуулийн мэргэжилтэн М.Золзаяа сургалт зохион байгуулсан.
4. 2017 оны 10 дугаар сарын 11-ний өдөр Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагаас зохион байгуулсан “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг илрүүлэх, ярилцлага авах болон тусламж үйлчилгээнд хамруулах” заавар боловсруулах тухай танилцуулга, хэлэлцүүлэгт Харьяатын газрын ахлах мэргэжилтэн, мөн 10 дугаар сарын 23-ны өдөр Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимаас зохион байгуулсан “Чөлөөт бүсийн хууль эрх зүйн орчин, экспорт, импортын боломж” сэдэвт сургалтад Боомт, орон нутгийн хэлтсийн мэргэжилтэн тус тус оролцов.

### **Гурав. Засгийн газарт хүргүүлэх сарын мэдээнд тусгах ажил**

1. Цахим визийн хүсэлтийн систем “evisa.mn” -ийг 2017 оны 10 дугаар сарын 03-ны өдөр нээж, ажиллагаанд орууллаа.
2. Байгууллагын даргын 2017 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн А/488 дугаар тушаалаар Гадаадын иргэн, харьяатын газрын “Ярилцлагын өрөө ашиглах заавар”-ыг баталж байгууллагын цахим Хуулийн санд байршуулсан.
3. Мөн Гадаадын иргэн, харьяатын газрын даргын 2017 оны 10 дугаар 05-ны өдрийн А/462 дугаар тушаалаар “Гадаадын иргэдийн шилжилт хөдөлгөөн, тулгамдаж буй асуудлыг тодорхойлох, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль тогтоомжийг боловсронгуй болгох зорилгоор эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулах” Ажлыг хэсгийг байгуулж, эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулах бэлтгэл ажлыг бүрэн хангасан бөгөөд хурлын

хэлэлцүүлгийг 2017 оны 11 дүгээр сарын 03-ны өдөр Гадаад хэргийн яамны “Зөвшилцөл танхим”-д зохион байгуулахаар төлөвлөөд байна.

4. Авлигатай тэмцэх газраас 2017 оны 03 дугаар сард тус байгууллагын 2014-2016 онд авч хэрэгжүүлсэн арга хэмжээнд хийсэн шалгалтын тайлан үр дүнгийн талаар 2017 оны 10 дугаар сарын 05-ны өдөр танилцуулсан. Тайланг хэлэлцүүлэхэд Авлигатай тэмцэх газрын дарга, тэргүүн комиссар Х.Энхжаргал, дэд дарга, эрхэлсэн комиссар Ц.Нямдорж, Төрийн албаны зөвлөлийн орон тооны гишүүн С.Цэдэндамба, Улсын ерөнхий аудиторовын зөвлөх А.Энхбат, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Баясгалан болон Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа агентлагийн дарга, удирдах албан тушаалтнууд оролцсон бөгөөд Гадаадын иргэн, харьяатын газраас байгууллагын дарга Д.Мөрөн, Тамгын газрын дарга М.Төрбат, Эрх бүхий албан тушаалтан М. Золзаяа нар оролцов.
5. Тайлангийн хугацаанд тус байгууллагад шинээр томилогдохоор болон дэвшин томилогдохоор нэр дэвшсэн 3 албан хаагчийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хүлээн авч 2017 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 1-06/3169, мөн сарын 25-ны өдрийн 1-06/3233, дугаар албан бичгүүдээр тус тус Авлигатай тэмцэх газарт хянуулахаар хүргүүлэв. Мөн шинээр томилогдсон 4, их хэмжээний өөрчлөлтөө мэдүүлсэн 3 нийт 7 албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд хүлээн авч, баталгаажуулсан.
6. 2017 оны 10 дугаар сарын 04-ний өдөр ЕАБХАБ–ын Элчин сайд тусгай төлөөлөгч Х.Мадина Ярбуссиноваг, мөн сарын 05-ны өдөр БНТУ-ын Онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайд М.Ахмет Язал, ТИКА-ын Улаанбаатар дахь хөтөлбөр зохицуулагч Вейсел Чивтжи нарыг байгууллагын дарга Д.Мөрөн тус тус хүлээн авч уулзан, БНТУ-ын Элчин сайдтай хэвлэлийн тоног төхөөрөмж хүлээн авах болон Туркийн цагаачлал, шилжилт хөдөлгөөний байгууллагатай хамтын ажиллагааг өргөжүүлэх талаар хэлэлцэв.
7. 2017 оны 10 дугаар сарын 10-ны өдөр АНУ-ын Төрийн Департаментийн зөвлөх Пол Шотт, Жей Наш, Шеннон Ратлидж нарыг байгууллагын дарга Д.Мөрөн хүлээн авч уулзан, цөмийн болон үйл олноор хөнөөх зэвсгийн үл дэлгэрүүлэх хяналтын тогтолцооны судалгааны асуултуудад тус газартай холбоотой тодорхой хариулт өгч, санал солилцлоо.
8. 2017 оны 10 дугаар сарын 10-наас 13-ны өдрийн хооронд Монгол, Хятадын хилийн боомт, тэдгээрийн дэглэмийн тухай Монгол Улсын Засгийн газар БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр"-ийн хэрэгжилтийг хангах тухай удирдах албан тушаалтнуудын түвшний 6 дугаар уулзалтад Боомт, орон нутгийн хэлтсийн дарга, ахлах мэргэжилтэн оролцсон.
9. 2017 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн байдлаар Гадаадын иргэн, харьяатын газрын төвлөрүүлэн захирагч нийт 4,847,758,200.00 /дөрвөн тэрбум найман зуун дөчин долоон сая тавин найман мянга хоёр зуун/ төгрөгийн төлөвлөгөөтэйгөөс 4,077,472,744 /дөрвөн тэрбум далан долоон сая дөрвөн зуун далан хоёр мянга долоон зуун дөчин дөрвөн/ төгрөгийн буюу 85% гүйцэтгэлтэй ажилласан байна.

10. 2017 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар өссөн дүнгээр 3,348,753,162 /Гурван тэрбум гурван зуун дөчин найман сая долоон зуун тавин гурван мянга нэг зуун жаран хоёр/ төгрөгийн тэмдэгтийн хураамжийн орлого, 579,060,000 /таван зуун далан есөн сая жаран мянган/ төгрөгийн хүү торгуулийн орлого, 135,794,110 /Нэг зуун гучин таван сая долоон зуун ерэн дөрвөн мянга нэг зуун арван/ төгрөгийн визийн хуудасны орлого нийт 4,063,607,272 /дөрвөн тэрбум жаран гурван сая зургаан зуун долоон мянга хоёр зуун далан хоёр/ төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлээд байна.
11. Гадаадын иргэн харьяатын газар 2017 онд 247,000,000 /Хоёр зуун дөчин долоон сая/ төгрөгийн нормын хувцас худалдан авах төлөвлөгөөтэйгээс 2017 онд худалдан авах ажиллагааг зохион байгуулж 19 багцын 246,820,000 /Хоёр зуун дөчин зургаан сая найман зуун хорин/ төгрөгийн нормын хувцас худалдан авах гэрээ хийсэн. 2017 оны 10 сарын 25-ны байдлаар нормын хувцас бэлтгэн нийлүүлэгч нарт 240,180,325 /Хоёр зуун дөчин сая нэг зуун наян мянга гурван зуун хорин таван/ төгрөгийн санхүүжилт олгож, 215,889,100 /Хоёр зуун арван таван сая найман зуун наян есөн мянга нэг зуун/ төгрөгийн нормын хувцас хүлээн аваад байна. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн дагуу 3 дугаар улирлын гүйцэтгэлийн тайланг гаргаж, Хууль зүй, дотоод хэргийн яамны Санхүү хөрөнгө оруулалтын хэлтэст 2017 ны 09 дүгээр сарын 29-ний өдрийн 1-07/3067 дугаар албан бичгээр хүргүүлсэн.
12. Тайлант хугацаанд 1800-1882 утсанд холбогдсон 625 иргэн, үйлчлүүлэгчдэд виз, визийн зөвшөөрөл, 303 иргэн, үйлчлүүлэгчдэд оршин суух зөвшөөрөл, 736 иргэн, үйлчлүүлэгчдэд холбогдох бусад асуудлаар зөвлөгөө, мэдээлэл өгч ажиллав.

### **Дөрөв. Байгууллагын үндсэн чиг үүрэгтэй холбоотой ажил**

#### **1. Виз, бүртгэлийн чиглэлээр /Хавсралт 2/**


Гадаадын иргэн, харьяатын газар нь тайлангийн хугацаанд түр ирэгч, албан болон хувийн хэргээр оршин суухаар ирэх гадаадын иргэдэд холбогдох төрийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, иргэний хүсэлтийг үндэслэн 1019 визийн зөвшөөрөл, 1950 виз олгож, гадаадын болон өөрийн орны иргэдээс хувийн журмаар гадаадын иргэдийг урих хүсэлтийг хянан 11 гадаадын иргэнд Монгол Улсад хувийн хэргээр зорчих урилга олгосон байна.

Төрийн захиргааны байгууллагуудын зөвшөөрлийг үндэслэн 1348 гадаадын иргэнд Монгол Улсад оршин суух зөвшөөрөл олгож, 2547 гадаадын иргэний оршин суух зөвшөөрлийн хугацааг сунган, оршин суух зөвшөөрөлтэй 3938 гадаадын иргэний бүртгэлд хасалт хийн, статус нь өөрчлөгдсөн 23 гадаадын иргэний визийн ангиллыг сольсон.

Монгол Улсад түр ирэгчээр ирсэн 1388 гадаадын иргэнийг бүртгэж, нутаг буцсан, статус өөрчлөгдсөн 1795 гадаадын иргэний бүртгэлд хасалт хийж, цагаач, гэр бүлийн шалтгаанаар оршин суугаа 218 иргэний хувийн хэрэгт баяжилт хийлээ.

Монгол Улсад 90 хүртэл хоногийн визтэй ирсэн, мөн визгүй зорчдог түр ирэгч гадаадын иргэдээс тус улсад байх хугацааг сунгуулах хүсэлтийг хянан 348 гадаадын иргэний байх хугацааг 30 хүртэл хоногоор сунгасан.

Тайлангийн хугацаанд “Монгол Улсад оршин суух үнэмлэх” 1803 ширхэгийг шинээр хэвлэн, 2419 ширхэг үнэмлэхний хүчинтэй хугацааг сунгаж, 49 ширхэг үнэмлэхэд хаягийн хөдөлгөөний бичилт хийж, Монгол Улсад цагаач болон хувийн хэргээр оршин сууж буй 8 иргэнд регистрийн дугаар олгон, үйлчилгээний зааланд нийт 3083 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийг хүлээн авч, 113 иргэнд цахимаар хариу өгсөн.



2017 оны 10 дугаар сарын тоон үзүүлэлтийг өмнөх оны 10 дугаар сарын үзүүлэлттэй харьцуулахад виз, визийн зөвшөөрөл, хувийн урилга, визийн сунгалт хэлбэлзэл багатай бол оршин суух зөвшөөрөл олголт 866-аар буурч, түр ирэгчийн бүртгэл 920-иор, түр ирэгчийн хасалт 1051-ээр тус тус буурсан байна. Түүнчлэн Монгол Улсад оршин сууж буй гадаадын иргэдэд бүртгэлээр хяналт тавих, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах ажлын хүрээнд 2017 оны 09 дүгээр сарын 12-ны байдлаар оршин суух зөвшөөрөл авсан нийт гадаадын иргэдийн мэдээллийг нэгтгэн гаргаж, оршин суух зөвшөөрлийн хугацаа дууссан, хугацаа хэтрүүлсэн 1960 гадаадын иргэдийн мэдээллийг хяналтын улсын байцаагч нарт хуваарилан Монгол Улсаас гарсан эсэхийг тогтоосон ба 1876 иргэн хасалт хийлгээгүй тус улсаас гарсан байсныг шалгаж тогтоон, нөхөж хасалт хийсэнтэй холбоотой оршин суух зөвшөөрөл хасалт 1736-аар нэмэгдсэн байна.

## 2. Харьяатын чиглэлээр /Хавсралт 3/

Монгол Улсын харьяат болох хүсэлт гаргасан Бүгд Найрамдах Хятад Ард Улсын 3 иргэний хүсэлтэд санал авах тухай 2017 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн 01-04/3125 дугаар албан бичгийг Цагдаагийн ерөнхий газар, Тагнуулын ерөнхий газар, Оюуны өмч улсын бүртгэлийн ерөнхий газарт тус тус хүргүүлсэн.

Монгол Улсын харьяат болох хүсэлт гаргасан 5 иргэнтэй байгууллагын даргын 2016 оны А/65 дугаар тушаалаар баталсан “Монгол Улсын харьяат болох хүсэлт гаргагчтай ярилцлага хийх журам”-ын дагуу 2017 оны 10 дугаар сарын 25-



6	ХБНГУ			1		1			2
7	БНИтали Улс							1	1
<b>Нийт</b>				<b>1</b>		<b>34</b>	<b>4</b>	<b>11</b>	<b>50</b>

Тайлант хугацаанд 7 улсын 50 иргэнийг хориг арга хэмжээгээр албадан гаргасныг хүснэгтээр үзүүлэв.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 34 дүгээр зүйлд заасан үндэслэлээр 2017 оны 10 дугаар сард 3 улсын 4 иргэнийг Монгол Улсаас гарахыг түдгэлзүүлж, 2 улсын 2 иргэний хилээр орох эрхийг сэргээж, 12 улсын 40 иргэний гарахыг түдгэлзүүлсэн шийдвэрийг хүчингүй болгосон байна.

Монгол Улсад байх хөрөнгийн эх үүсвэрээ тодорхойлж чадаагүй, Монгол Улсад орох визгүй болон ирсэн зорилгодоо нийцсэн зохих ангиллын визгүй нийт 68 иргэнийг Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйл, Засгийн газрын 2010 оны 338 дугаар тогтоолд тус тус заасны дагуу орох чиглэлд хил нэвтрүүлэлгүй буцаасан.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 37 дугаар зүйлд заасан зөрчил гаргасан үндэслэлээр 7 улсын 50 иргэнийг Монгол Улсаас албадан гаргасан ба энэ 10 дугаар сард гарах сануулга болон албан шаардлага өгөөгүй байна.

#### Гарахыг түдгэлзүүлсэн:

№	Улсын харьяалал	Зүйлчлэл			Нийт
		34.2.1	34.2.2	34.2.3	
1	БНСУ	1		1	2
2	Румын	1			1
3	АБНЕгипетУ	1			1
<b>Нийт</b>		<b>3</b>	<b>0</b>	<b>1</b>	<b>4</b>


#### Түдгэлзүүлснийг хүчингүй болгосон:

№	Улсын харьяалал	Зүйлчлэл			Нийт
		34.2.1	34.1.2	34.1.3	
1	АНУ			1	1
2	БНХАУ			17	17
3	ОХУ			6	6
4	БНСУ			8	8
5	БНАСАУ			1	1
6	Бангладеш			1	1
7	БНСВУ			1	1
8	ХБНГУ			1	1
9	БНИталиУ			1	1
10	БНЧехУ			1	1
11	Туркменстан			1	1
12	БНКазУ			1	1
<b>Нийт</b>		<b>0</b>	<b>0</b>	<b>40</b>	<b>40</b>



Хан-Уул дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн захирамжаар БНХАУ-ын 1 иргэнийг энэ оны 09 дүгээр сарын 29-ний өдөр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Баривчлах төвийн дэргэдэх Гадаадын иргэнийг саатуулах байранд саатуулсан.

### Зөрчил шийдвэрлэсэн байдал:



Тайлангийн хугацаанд 9 удаагийн төлөвлөгөөт, 12 удаагийн төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг зохион байгуулж, нийт 79 аж ахуйн нэгж, байгууллага, 2572 гадаадын иргэнийг хамруулснаас Зөрчлийн тухай хуульд заасан зөрчил гаргасан 365 гадаадын иргэн, 116 аж ахуйн нэгж, байгууллага /399 иргэн/, 3 уригч иргэн /3 иргэн/-д торгууль ногдуулж, 175 сая 040 мянган /Нэг зуун далан таван сая дөчин мянган/ төгрөгийг улсын төсөвт төвлөрүүллээ. 2017 оны 10 дугаар сарын торгуулийн орлогыг өмнөх оны мөн үеийн үзүүлэлттэй /130 сая

752 мянган төгрөг/ харьцуулахад 44 сая 288 мянган төгрөгөөр өссөн байна.

### ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗАР